

“Оллоо ХК”-ий 2015 оны ХЭХ-ийн

ээлжит хурлын протокол

2015.04.27

Улаанбаатар хот

“Оллоо” ХК-ий ХЭХ-ийн ээлжит хурал 2015.04.27 –ний өдрийн 16.00 цагт Улаанбаатар хот, Компаний байранд хуралдав.

Бүүвэйбаатар: “Оллоо ХК” ий хувьцаа эзэмшигч та бүхэнд энэ өдрийн мэнд хүргье. 2015 оны хувьцаа эзэмшигчдийн хурлыг албан ёсоор эхлүүлье. Хурлын ирцийг танилцуулъя. Ирц хүрч байвал хурал үргэлжилнэ.

Одоогийн байдлаар 1799205 хувьцаа эзэмшигч Asia Pasific security-г төлөөлж Янжиндулам,

805147 ширхэг хувьцаа эзэмшигч Эй Пи Ай Пи-г төлөөлж Янжиндулам ,

274804 ширхэг хувьцаа эзэмшигч Frontier-ээс захирал Масатару ,

10 ширхэг хувьцаа эзэмшигч Гацуурт треди-ийг төлөөлж П.Нямдорж,

7568 ширхэг хувьцаа эзэмшигч ТДБ капитал-ийг төлөөлж Г.Гансүх ,

141334 ширхэг хувьцаа эзэмшигч Бүүвэйбаатар,

2534470 ширхэг хувьцаа эзэмшигч Ц.Энхцэцэгийг төлөөлж П.Бүүвэйбаатар нар ирсэн байна. Мөн хөрөнгийн биржээс ажиглагчаар А.Маналжав ирсэн байна.

Ингээд нийт дүнгээр 5562538 ширхэг хувьцаа эзэмшигч ирсэн ба ирц 57,3 хувьтай байна. Ирцийн байдал 50 хувиас их байгаа тул хурлыг хүчин төгөлдөр гэж үзээд эхэлье.

Бүүвэйбаатар: Ингээд бүх гишүүдийн хурал нээснийг мэдэгдье. Та бүхэнд хурлын материал урьдчилан тараасан байгаа дээрхи дэгийн дагуу хурал явагдана.

Хурлын дэгийн 1-рт байгаа 2014 оны санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтээр 2014 оны санхүүгийн тайлан хангалттай гэж гарсан байгаа. 2014 оны үйл ажиллагаатай холбоотой асууж лавлаж тодруулах зүйл байвал асууж болно.

Мөн 2014 онд хийгдсэн хамтран ажиллах гэрээнүүд мөн 2014 оны хийж гүйцэтгэсэн ажлууд байна . Бид 2014 онд Вэб дизайнаа шинэчилсэн. Вэб дизайныг шинэчлэхэд өөрсдийн хүчээр компаний дотоод нөөц бололцоогоор шинэчлэхэд хүндрэлтэй байсан. Тиймээс вэб дизайн хийдэг мэргэжлийн байгууллагатай ажлын хөлсөө тохиролцоод албан ёсоор гэрээ байгуулж хийлгэсэн байгаа. Манай энэ вэб дизайн нь персонал компьютер , гар утсан дээр гардаг. Одоогоор зөвхөн apple дээр ажиллахгүй байгаа энэ нь манай санхүүгийн байдалтай холбоотойгоор хийгдэж хараахан амжаагүй байгаа.

Үүний дараагаар манай ollo.mn руу хандах уншигчдын тоо хандалт нэмэгдсэн өөрөөр хэлбэл бид нар 17-р байрнаас 5-р байр руу орсон байгаа . Энэ бол нэгдүгээрт Вэб дизайнаа шинэчилсэн, хоёрт гар утсан дээр апплекейшн хийсэнтэй холбоотойгоор хандалтын тоо нэмэгдсэн.

Дараагаар нь хараат бус Аудиторын тайлан , санхүүгийн тайлан , орлогын тайлан байна. Үүнтэй холбоотойгоор Гүйцэтгэх захирлаас асууж тодруулах зүйл байвал асууж болно.

Санхүүгийн зохицуулах хорооноос ирсэн шаардлагын дагуу хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх , хөрөнгөжүүлэх тухай асуудлыг хэлэлцэж санхүүгийн зохицуулах хороонд тайлагнах ёстой. Энэн дээр бид нар бичилтийг яаж осрчлөх ёстой вэ , компания яаж хөрөнгөжүүлэх ёстой гэдэг тал дээр шийдвэрээ гаргаж , гаргасан шийдвэрийнхээ дагуу

санхүүгийн зохицуулах хороонд тайлагнах үүрэгтэй байгаа. Та бүхэн бас саналаа хэлэх байх. Үүн дээр компаний зүгээс урьд өмнө нь өөр компани-тай хамтран хийж байсан Оллоо GPS аяллын хөтчийг сүүлийн хоёр жилийн хугацаанд мэргэжлийн хүмүүстэй хамтран ажиллаж , газрын зургийг 2014 оны байдлаар зуруулж сарын өмнө шинэчилсэн хувилбрыг гаргасан. Энэ ажлыг орлого хуваах гэрээтэйгээр GPS-ийн гарах зардлыг хасаад үлдсэн мөнгийг 50:50 хувиар хуваах бизнесийн гэрээ байгуулсан. Үүнээс бид орлого, болон санхүүгийн хувьд дээшлэх маш өндөр хүлээлттэй байгаа. Энийг өмнөх туршлагауд дээр үндэслэн гаргасан. Есөн сар хүртэл борлуулалтыг идэвхитэй хийнэ.

Гансүх: урьд нь зарагдаж байсныг мэднэ.

Бүүвэйбаатар: Тухайн үед бид нар зөвхөн брендээ л түрээслэж байсан. Бидний хувьд бренд нэрээ түрээслээд энүүгээрээ бид ямар ч хариуцлага хүлээхгүй , тухайн компани бүх хариуцлага эвдрэл гэмтэл , зар сурталчилгаа санал гомдлоо , компани өөрөө хүлээх нөхцөлтэйгөөр гэрээ байгуулан ажилласан байгаа.

Харин энэ удаад эрсдлийг хамт үүрнэ. Зар сурталчилгааг өөрсдийн вэб сайтаараа явуулна. Мөн санхүүгийн асуудлыг бид өөрсдөө шийдэн тухайн бүтээгдхүүнийг захиалж авчран энэхүү ажлыг зохион байгуулаад явж байна. Та бүхэнд 2014 оны тухай асуулт байна уу?

Гансүх: Энэ Оллоо GPS зохиогчийн эрхийн маргаантай гэсэн энэ асуудал юу болсон бэ? дахиж ямар нэгэн асуудал гарах уу?

Бүүвэйбаатар: Энэ тал дээр өмнө хийгдэж байсан гэрээнээс өөр тухайн программыг ажилуулж байгаа хүмүүс өөрсдөө оюуны өмчийн болон , техник технологийн асуудлыг хариуцна. Оллоо ХК-ий хувьд оюуны өмчийн тал дээр ямар нэгэн эрсдлийг хүлээхгүй гэсэн гэрээтэй байгаа. Бидний хувьд оюуны өмчийн маргаан гарвал гэрээ хийсэн газартайгаа л харицана. Энэ удаад брендээ нэг талаар түрээслэж байгаа мэт боловч , орлогоо арай илүү авна гэсэн үг.

Нямдорж: Асуух зүйл байна. GPS урьд нь хэдий хэмжээний зарагдаж байсан бэ , барагцаа байгаа юу?

Бүүвэйбаатар: Энэ тал дээр бол тэд эд гэсэн тоо байхгүй , тухайн үед нэрээ ашиглуулаад мөнгөө авчихсан, тухайн компани манай нэрийг ашиглаад бүтээгдэхүүнээ борлуулж байсан гэсэн үг. Сая гэрээ байгуулсан компани бол өмнөх компаниас өөр газар байгаа өмнөх газартайгаа холбоо тасраад гурван жил болж байна.

Нямдорж: Энэ 2014 онд вэб дизайн шинэчилсэн байна , үүнийг хэдэн төгрөгний төсөвтэйгөөр хийсэн ажил бэ?

Цагаанган: 30 сая төгрөгний өртөгтэйгөөр хийгдсэн ажил байгаа. Сайтын хувьд бол засаж залруулах жижиг зүйлүүд одоо ч хийгдээд явж байна. Төлбөр гүйцэт хийгдээгүй тухайн компани 3 жилийн дотор вэбийн ерөнхий хөгжүүлэлтийг хариуцна гэсэн гэрээтэй байгаа.

Нямдорж: Яг одоогын байдлаар хэдэн хүн ажиллаж байна вэ?

Цагаанган: Одоогын байдлаар 9 хүн ажиллаж байгаа.

Нямдорж: Зардал их өндөр байна.

Цагаанган: Урьд нь бол 10 гаран хүнтэй байсан. Одоо ерөнхийдөө цөөрсөн 9 хүн ажиллаж байна. Үйл ажиллагааны зардлын дүнгээс цалингын зардал 68 сая , биет бус хөрөнгийн дүн жилд 97 саяар хорогдож байгаа , үлдсэн зардал нь серверийн түрээс , ашиглалтын зардал гэх мэт зардлууд гарч байгаа. Манайх өнөөдрийн байдлаар Alexa.com дээр 4-рт бичигдэж байна.

Гансүх: Ухаалаг гар утсан дээр хийсэн зүйл байгаа юу?

Бүүвэйбаатар: Android утсан дээр манай сайт бүрэн хэмжээгээрээ гарч ирдэг байгаа. Үүнийг хийхийн тулд бас их судалсан манайх одоогоор хамгийн сайн дизайнтай сүүлийн үеийн апплейшн гэж хэлж болно.

Нямдорж: Энэ багтаамжаасаа болж ийм үнэтэй байдаг уу? Компаний вэб сайтын ханш гайгүй байдаг юм байна лээ.

Цагаанган: Манайх IT-гийн мэргэжлийн компаниар хийлгэсэн байгаа. Энэ иргэд бас арай илүү чанартай дизайнтай сүүлийн үеийнх гэж хэлж болно.

Нямдорж: Гэрчилгээний өөрчлөлт гэж энэ тэрбум гээд буруу бичигдсэн гэсэн үгүү.

Цагаанган: Санхүүгийн зохицуулах хорооноос ирсэн шаардлага байгаа. Гэрчилгээн дээр 1 тэрбум 500 сая гээд бичигдсэн байгаа. Яг манай хөрөнгө 970 саятай байгаа тэрийг залруулж гэрчилгээнд өөрчлөлт оруулах тухай асуудал. Сая санхүүгийн зохицуулах хорооноос шалгалт орсон. Түүний дагуу өөрчил гэсэн шаардлага ирсэн. Харин өөрчлөхдөө заавал хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэр гарч байж өөрчлөх ёстой.

Бүүвэйбаатар: Энэ нэмэгдүүлэх хөрөнгөжүүлэх асуудлыг бид нар бүх гишүүдийнхээ хурлаар шийдэх ёстой байсан уу? яаж шийдвэл болох вэ?

Нямдорж: Энийг шийдэх арга зам нь юу байна.

Цагаанган: Санхүүгийн зохицуулах хорооноос шалгалт ирсэн тэр шаардлагын дагуу өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх , хөрөнгөжүүлэх асуудлыг бүх гишүүдийн хурлаар хэлэлцэх ёстой гэсэн журмын дагуу оруулсан байгаа.

Нямдорж: Хэлэлцэж болноо , гэхдээ юу хэлэлцсэнээ мэдэхгүй зурж болохгүй биз дээ.

Бүүвэйбаатар: Энийг яаж хөрөнгөжүүлж байсан туршлага бас өөрт нь байхгүй байна аа, санхүүгийн зохицуулах хороонд , та нар ингэж хий гэсэн тийм зүйл алга. Бид нар яаж өөрсдийгөө хөрөнгөжүүлэхээ мэдэхгүй байна. Нэг санал байна GPS-ний нэмэлт орлогоос орж ирж байгаа хөрөнгөнөөс үл хөдлөх хөрөнгө худалдаж авах замаар компаниа хөрөнгөжүүлье, энэ бол 2 юмуу 3 жилийн дотор гэсэн л шийдэл байна.

Нямдорж: Оллоо дээр байгаа англи хэлний хичээл , контентууд байгаа тэднийг үнэлж болдоггүй юмуу?

Бүүвэйбаатар: Болно оо

Нямдорж: Тэгвэл тэр зүйлээ үнэлээд хөрөнгөжүүлж болно биз дээ.

Цагаанган: Тэдгээрийг үнэлээд л тавингуут биет бус хөрөнгө болоод элэгдэл тооцоод , эргээд хасагдчихна. Ууг нь бол бидний үзэж байгаагаар хөрөнгө маань улам өргөжөөд , нэмэгдээд улам боловсронгуй болоод байгаа болов ч , нягтлан бодох бүртгэл дээрээ элэгдэл хорогдол заавал тооцох ёстой байгаа тэгхээр жил жилээр багсаад яваад байна гэсэн үг.

Нямдорж: Тэгвэл GPS-ээс орж ирсэн нэмэлт орлогоосоо үл хөдлөх хөрөнгө худалдаж авах замаар компаниа хөрөнгөжүүлнэ гээд ойлгочихож болохуу?

Бүүвэйбаатар: Компаний одоо хийж байгаа үйл ажиллагаа маань мөнгөн хэлбэрээр хөрөнгөжүүлэх тал дээр болохгүй байнаа , орж ирж байгаа орлогоосоо гадна нэмэлтээр орлого бий болгох , түүгээрээ үл хөдлөх хөрөнгө худалдаж авах замаар компаниа хөрөнгөжүүлье гэсэн бодолтой байна. Та бүхэнд өөр санал байна уу?

Нямдорж: ТУЗ-ийн гүшүүдийг сонгохгүй баталчихдаг юмуу?

Цагаанган: Энэн дээр бол саналаа өгөх ёстой байсан. Саналыг 04 сарын 06 хүртэл хүлээж авах байсан. Биржээр тараалгасан гарын авлага дээр санал өгөх хугацаа гэж байгаа. Дээрхи хугацаанд ямар ч санал ирээгүй байгаа.

Бүүвэйбаатар: Эргээд энэ 9 хүнтэй өрсөлдөх гэхээр санал нь хүрэх хүн байхгүй байгаа. Энэ 9 хүний хамгийн бага санал авч байгаа нь гишүүн болж байгаа.

Нямдорж: Энэ 9 гишүүн бүгд хамааралтай гишүүд болоод байна. Хараат бус гээд 3 гишүүн байх ёстой биз дээ.

Бүүвэйбаатар: Батбаяр, Эрдэнэжав энэ хоёр хүн бол хараат бус гишүүд бид нарт огт хамааралгүй хүмүүс байгаа.

Нямдорж: Энэ хоёр хүн эргээд үйл ажиллагаанд оролцдог уу?

Бүүвэйбаатар: Хурал дээр ирэх нь ирнэ гэхдээ одоо үйл ажилагаанд оролцох нь багасаад байгаа ер нь бол сольё гэсэн бодолтой байгаа.

Бүүвэйбаатар: За санал шүүмжлэл явсан байгаа, өөр яриж хэлэх зүйл байна уу, байхгүй бол саналаа нэгтгэж танилцуулаад хуралаа өндөрлөе?

Нямдорж: 2015 оны төлөвлөгөөн дээр контент борлуулах гэж байна энэний талаар яриач.

Бүүвэйбаатар: Энэ контент борлуулах гэдэг бол: Бид юнивишны кино сангаас нэг кино түрээслэж үзэхэд 2000 төгрөг байдаг тэрийг хэлж байгаа. Гэхдээ одоохондоо яг энэ тэрийг борлуулна гэсэн төлөвлөгөө байхгүй байна.


Бүүвэйбаатар: Янжиндулам манай хуралд анх удаа компаниа төлөөлөн итгэмжлэхээр оролцож байгаа таньд хэлэх зүйл байна уу?

Янжиндулам: Би энэ хуралд компаниа төлөөлөн оролцож байна. Хурлаар хэлэлцсэн асуудалд хэлэх зүйл байхгүй. Дэмжиж байна. Хурлын талаар цааш Гүйцэтгэх удирдлагадаа уламжилнаа.

Бүүвэйбаатар: Ингээд нэгтгэсэн санлыг танилцуулья.

1. Д.Нармандахын оронд Н.Батжинг ТУЗ-ийн гишүүнээр томилохыг 100% дэмжсэн байна
2. ТУЗ-ийн нэр бүхий 9 гишүүнийг улираан томилохыг 99,9% дэмжсэн байна.
3. Санхүүгийн зохицуулах хорооноос ирсэн шаардлагын дагуу Компаний гэрчилгээнд өөрчлөлт оруулахыг 100% дэмжсэн байна.
4. Санхүүгийн зохицуулах хорооноос ирсэн шаардлагын дагуу хувь хийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх хөрөнгөжүүлхийг 100% дэмжсэн байна.

Хувьцаа эзэмшигчдийн хуралд идэвхитэй оролцсон та бүхэнд баярлалаа хурал хаасныг мэдэгдье.



P. Buuvaybaatar

П.БҮҮВЭЙБААТАР

Г.ГОЁЦЭЦЭГ